



**ГЕРМЕС ЦЕНТР ХК-ИЙН 2022 ОНЫ 3-Р УЛИРЛЫН
САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /Маягт 2/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа: /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/	2022 оны 06-р сарын 1-ний өдрөөс 2022 оны 9-р сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	«Гермес Центр» ХК УБГД: 9010001069 Үнэт цаасны код: MN00HRM05287 Утасны дугаар: (+976) 11 301 577
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр:	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны чиглэл :	Түрээсийн
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг:	78 543 001
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Улирлын тайланг бэлтгэсэн: О.Энхтуяа (Нягтлан бодогч) Д.Эрдэнэсүрэн (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга) Хянасан: Б.Оюунцэцэг (Гүйцэтгэх захирал)
1	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан (Хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана).
	Санхүүгийн байдлын үзүүлэлт
	Орлогын тайлан
	Өмчийн өөрчлөлтийн тайлан
	Мөнгөн гүйлгээний тайлан
2	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт
	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны тогтоолыг хавсаргав.
3	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан дүгнэлт
3.1	Үйл ажиллагааны үр /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд
	ROA = 0.1143 ROE = 0.1188 EPS = 12.39
3.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт
	ROTA = 0.1270

3.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	Манай компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.
3.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.
4	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана./	
<i>Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно.</i>		
5	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
<i>Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.</i>		
6	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
<p>Төлөөлөн Удирдах Зөвлөл: Манай компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн дэргэд "Цалин урамшууллын хороо", "Нэр дэвшүүлэх хороо", "Аудитын хороо"-д дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Цалин урамшууллын хороо - Дарга Д.Оюунсүрэн, гишүүд Д.Алтанчимэг, Н.Мөнхзул 2. Нэр дэвшүүлэх хороо - Дарга Б.Оюунцэцэг, гишүүд Б.Амарсанаа, Ц.Түвшинжаргал 3. Аудитын хороо - Дарга Д.Туяа, гишүүд Н.Батсайхан, Б.Алтангэрэл <p>Компанийн ТУЗ-ийн ээлжит хурал 2022 оны 8-р сарын 26-ны өдөр хуралдаж дараах тогтоол шийдвэрүүдийг гаргалаа. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Компанийн эхний хагас жилийн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлан батлав. 2. Компанийн эхний хагас жилийн цэвэр ашгаас 629.9 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахаар шийдвэрлэв. 3. Компанийн эхний хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээг 8 төг 02 мөнгөөр тогтоож, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 9-р сарын 16-ны өдрөөр тасалбар болгож, 9-р сарын 20-ны өдрөөс эхлэн хувьцаа эзэмшигчдэд олгохоор шийдвэрлэв. 4. "Компанийн засаглалын кодексийн зарчим"-д нийцүүлэн компанийн дараах дүрэм, заавар, журам, бодлогын баримт бичгүүдийг баталсан. <ol style="list-style-type: none"> 4.1 Компанийн ёс зүйн дүрэм - шинээр 4.2 Компанийн залгамж халааны бодлого - шинээр 4.3 Компанийн цалин урамшууллын бодлого - шинээр 4.4 Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого - шинээр 4.5 Компанийн эрсдэлийн удирдлагын заавар - шинээр 4.6 Компанийн дотоод хяналтын заавар - шинээр 4.7 Компанийн комплайнсын хяналтын заавар - шинээр 4.8 Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам - шинэчлэн 4.9 Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагааны журам - шинээр 4.10 Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам - шинээр 		
<p>ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо: ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь 2022 оны 7-р сарын 21-ний өдөр хуралдаж, компанийн эхний хагас жилийн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, үнэн зөв толилуулагдсан болохыг тогтоолоор батлав.</p>		
<p>Манай компани нь 2022 оны 9-р сарын 16-ны бүртгэлийн өдрөөр нийт 1024 хувьцаа эзэмшигчидтэй байсан бөгөөд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт ороогүй болно.</p>		

7

Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

Тайлант хугацаанд манай компанийн ТУЗ нэг удаа хуралдаж 5 тогтоол, мөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь нэг удаа хуралдаж 1 тогтоол шийдвэрийг тус тус баталсан бөгөөд гүйцэтгэх удирдлагын баг хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Компанийн ТУЗ-ийн хурлаас гаргасан тогтоол шийдвэрүүдийг мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс СЗХ болон МХБиржид хэвлэмэл байдлаар тогтмол хүргүүлж, мөн www.mse.mn, www.hermescenter.mn сайтуудад байршуулан олон нийтэд нээлттэй ил тодоор тайлагнан ажиллаж байна.

Компанийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, ногдол ашиг тараалтын тайлан зэрэг хугацаат тайлангуудыг тогтоосон хугацаанд багтаан СЗХ-нд хүргүүлсэн бөгөөд МХБ-ийн цахим хуудас болон өөрийн компанийн цахим хуудасд байршуулан олон нийтэд тайлагнан ажиллаж байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо: 2022 оны 10-р сарын 19-ний өдөр

Овог, нэр: Б.Оюунцэцэг

Албан тушаал: "Гермес Центр" ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



(Тамга /тэмдэг)

Овог, нэр:

Албан тушаал: "....." аудитын компанийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга /тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2022 оны 10-р сарын 19-ний өдөр

Овог, нэр: Д.Эрдэнэсүрэн

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:

Гарын үсэг: